ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

## 1. Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 7 дугаар хороолол, Ногоон нуурын гудамжинд байрлах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байрны 1 давхрын 104 тоот, 19.37 м.кв талбайг “Хуулийн номын худалдааны зориулалтаар” түрээслүүлнэ.

## 2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

| | |
|---|---|
| Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа | 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 10:00 хүртэл |
| Материал хүлээн авах хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 7 дугаар хороолол, Ногоон нуурын гудамж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр, 2 давхар, 202 тоотод Бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгнө. |
| Материал нээх хугацаа, хаяг байршил | 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 10:30 цагт нээнэ.<br><br>Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр, 4 давхар, 403 тоот |
| Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ | 1 м.кв талбай 15 000 /арван таван мянга/ төгрөг<br>(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэв.) |
| Түрээслүүлэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл | Шаардахгүй. |
| Түрээслэгчид тавигдах шаардлага | • Хуулийн ном, хэвлэл дагнан худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байх;<br>• Хуулийн номын худалдааны чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн бол давуу тал болно. |
| Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл | • Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 51 дүгээр тогтоолын дагуу Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.<br><br>• Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай эсэхээ нотлох зорилгоор бүрдүүлэх материалыг бүрэн ирүүлнэ.<br><br>• Материалыг бүрэн ирүүлсэн, хамгийн өндөр оноо авсан нэг оролцогчийг сонгон шалгаруулна. |
| Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал | Оролцогч нь сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд бүрэн бүрдүүлж ирүүлнэ.<br>*Жич: Бүрдүүлсэн материалыг битүүмжилж материалын жагсаалтыг дугтуйны гадна талд бичсэн байна.*<br>1. Иргэний үнэмлэхийн хуулбар /Хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар/; |

| | |
|---|---|
| | 2. Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (өмнө хийж байсан ижил төстэй ажлын гэрээний хуулбар);<br>3. Санхүүгийн чадварыг нотлох баримт /иргэн бол харилцагч банкны тодорхойлолт /зээл/, сүүлийн 1 жилийн дансны хуулга, хуулийн этгээд бол сүүлийн 2 жилийн аудитлагдсан тайлан, татвар, нийгмийн даатгалын тодорхойлолт);<br>4. Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэх, нийгмийн даатгал төлсөн байдал;<br>5. Түрээслэх үнийн санал. |

**6. Түрээслэх хөрөнгийн талаарх мэдээлэл авах:**

Сонгон шалгаруулалтын талаарх заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 11-312686, 11-323363 дугаарын утсаар авна уу.

Цахим шуудан: uranchimeg@legalinstitute.mn, nomin@legalinstitute.mn